

Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

2017 оны 04 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2017 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллагаас 2561 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59 нэгж буюу 2.4 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 23 буюу 0.9 хувь нь санал, 2507 буюу 97.9 хувь нь өргөдөл, 31 буюу 1.2 хувь нь гомдол

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдол



байна.

Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 374 буюу 14.6 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 108 буюу 4.2 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 381 буюу 14.9 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 827 буюу 32.3 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 97 буюу 3.8 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 774 буюу 30.2 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 2462 буюу 96.1 хувийг шийдвэрлэж, 99 буюу 3.9 хувь нь ажиллагаанд байна.


Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2017 оны 1 дүгээр улиралд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 213 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48 нэгж буюу 29.1 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 2 буюу 0.9 хувь нь санал, 16 буюу 6.9 хувь нь гомдол, 195 буюу 91.5 хувь нь өргөдөл байна.




Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 18 буюу 8.5 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 34 буюу 16.0 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 25 буюу 11.7 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 5 буюу 2.3 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 25 буюу 11.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 106 буюу 49.8 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2017 оны 1 дүгээр улиралд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 122 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 56 буюу 46.0 хувь нь санал хүсэлт, 51 буюу 41.8 хувь нь гомдол, 12 буюу 9.8 хувь нь талархал, 2 буюу 1.6 хувь нь шүүмжлэл, 1 буюу 0.8 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 64 буюу 52.5 хувийг шийдвэрлэж, 58 буюу 47.5 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 19 буюу 29.7 хувийг 5 хоногийн дотор, 45 буюу 70.3 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2017 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 466 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 77 нэгж буюу 19.8 хувиар өсч, 501 алба хаагч холбогдсоны 415 буюу 82.8 хувь нь офицер, 84 буюу 16.8 хувь нь ахлагч, 2 буюу 0.4 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 408 буюу 87.6 хувийг барагдуулж, 58 буюу 12.4 хувь нь ажиллагаанд байна.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС